

▶ 15. ЯМАР ХУРААМЖ ТӨЛӨХ ВЭ?

- Гэрлэгчид хоёулаа ЧУ-д байнгын оршин суух зөвшөөрөлтэй бол - ямар ч хураамж төлөх шаардлагагүй.
- Гэрлэгчид хоёулаа байнгын оршин суух зөвшөөрөлгүй бол - 3 000 Крон төлдөг.
- Гэрлэгчидийн хэн нэг нь байнгын оршин суух зөвшөөрөлтэй бол - 2 000 Крон төлдөг.
- Гэрлэлтээ ажлын хувиараас өөр цагт, товчооны ажлын байрнаас өөр газарт бүртгүүлэхээр бол - 1 000 Крон төлдөг.

▶ 16. ГЭРЛЭХ ЁСЛОЛЫН ДАРАА ЯАХ ЁСТОЙ ВЭ?

- Гэрлэлтийн товчоо танд 30 хоногийн дотор **гэрлэлтийн гэрчилгээ (oddací list)** хийж өгнө (шашины гэрлэлт бол 33 хоногийн дотор). Гэрлэлтийн гэрчилгээ нь та нарын гэр бүлтэй гэдгийг нотлосон баримт учраас сайн хадгалах хэрэгтэй.
- Өөрийн харъяалалын дагуу дотоод хэргийн яамны цагаачлал шилжин сууршилтын албаны ажлын салбарт (ОАМР) 3 хоногийн дотор гэр бүлийн байдлын өөрчлөлтийн талаар мэдэгдээрэй. Гэрлэлтийн дараа өөр овог хэрэглэж байгаа тохиолдолд овогийн өөрчлөлтөө бас мэдэгдээрэй.
- ЕХ-ны гишүүн орны иргэн эсвэл түүний гэр бүлийн гишүүн гэр бүлийн байдлын, нэрийн өөрчлөлтөө 15 хоногийн дотор мэдэгдэнэ.
- Гэрлэлтийн дараа өөр овог хэрэглэж байгаа тохиолдолд элчин сайдын яамны шинэ паспорт хүссэн өргөдлөө гаргах ёстой. Элчин сайдын яамны газар танаас чех хэлээр буй таны гэрлэлтийн баталгааг албан ёсны орчуулагыг хүсэх байх - энэ тухай элчин сайдын газраа хэлээрэй.
- Шинэ паспорттай болсоны дараа дахин та дотоод хэргийн яамны цагаачлал шилжин сууршилтын албаны ажлын салбарт очиж бүртгүүлээрэй, магадгүй танд шинээр оршин суух зөвшөөрөл олгох ёстой байж болно.
- Элчин сайдын яамны эрх мэдэлд таны бичиг баримтыг шийдвэрлэж өгөх байдаг. Магадгүй танд өөрийн харьяат улсаас шинэ паспорт хүсэхийг зөвлөж болох юм.

▶ 17. ЧУ-Д ГЭРЛЭЛТЭЭР ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭХ БОЛОМЖУУД

Та урт хугацааны оршин суух зөвшөөрөлтэй таны эхнэр/нөхөр ижил зөвшөөрөлтэй- хоёулаа ижил урт хугацааны оршин суух зөвшөөрөлтэй байна. Оршин суух зөвшөөрлөө урт хугацааны гэр бүлийн виз болгон өөрчлөж болно.

Та урт хугацааны визтэй таны нөхөр/эхнэр байнгын оршин суух зөвшөөрөлтэй эсвэл орогнол олгогч (azyl-taj) – ДХЯ-ны цагаачлал хариуцсан ажлын албанаас байнгын оршин суух зөвшөөрөлтэй хүнтэй гэр бүл болсон гэдэг утгаар ЧУ-д урт хугацааны оршин суух зөвшөрөл хүсч болно. Ийм оршин суух зөвшөөрөлтэй гадаад иргэн ажлын зөвшөөрөл хүсэхгүйгээр хөдөлмөр эрхэлж болно, гэвч таны ажилладаг байгууллага ЧУ-д бүртгэлгүй бол нийтийн эрүүл мэндийн даатгалын системд хамрагдах эрхгүй.

Та урт хугацааны оршин суух зөвшөөрөлтэй, таны нөхөр/эхнэр ЧУ эсвэл ЕХ-ны гишүүн орны иргэн – ДХЯ-ны цагаачлалын албанаас ЧУ эсвэл ЕХ-ны гишүүн орны иргэний гэр бүлийн гишүүн гэсэн төрлөөр 2 жилийн түр зуурын (přechodný) оршин суух зөвшөөрөл хүсч болно (гэрлэлтээс өмнө та хамгийн багадаа 1 жилийн урт хугацааны визтэй байсан бол гэрлэлтээс хойш 1 жилийн дараа ч хүсч болно).

Та оршин суух зөвшөөрөлгүй, таны нөхөр/эхнэр ЧУ эсвэл ЕХ-ны гишүүн орны иргэн – ЧУ-д визгүйгээр хамгийн уртдаа 90 хүртэлх хоногоор байж болно. Энэ хугацаандаа ДХЯ-ны цагаачлалын албанаас ЧУ эсвэл ЕХ-ны гишүүн орны иргэнтэй гэр бүлийн гишүүн гэсэн төрлөөр түр зуурын (přechodný) оршин суух зөвшөөрөл хүсч болно.

Та оршин суух зөвшөөрөлгүй, таны нөхөр/эхнэр урт хугацааны эсвэл байнгын оршин суух зөвшөөрөлтэй – та гэр бүлийн зорилгоор оршин суух зөвшөөрөл авах эрхтэй, гэвч та энэ тухай өөрийн эх орон дах ЧУ-ын элчин сайдын яаман дээр өргөдлөө гаргана. Өргөдлийг шийдвэрлэх хугацаа 270 хоног.

▶ 18. ГЭРЛЭЛТЭНД ТӨЛӨӨЛӨН ОРОЛЦУУЛАХ ОНЦГОЙ ТОХИОЛДОЛД

- Гэрлэхийг хүсэгчидийн хэн нэг нь онцгой хүндэтгэх шалтгаанаар гэрлэх ёслолд оролцож чадахгүй бол гэрлэлтэнд төлөөлөн оролцуулах өргөдөл гаргаж болно.
- Нэн түрүүнд танай улс ийм гэрлэлтийг хүчинтэйд тооцно гэсэн тодорхойлолт шаардлагатай.
- Гэрлэлтийг төлөөлөн бүртгүүлэх зөвшөөрлийг аймгийн болон хотын захиргаа шийдвэрлэдэг: Прага, Брно, Пльзень хотын захиргаа.

▶ 19. ТА ӨӨР ЮУГ САЙН МЭДВЭЛ ЗОХИХ ВЭ?

Гэрлэлтэнд эрэгтэй эмэгтэй хүмүүс харилцан тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээнэ. Гэрлэгчид нь бие биедээ туслаж, хүүхдээ хамтдаа өсгөн хүмүүжүүлэх үүрэгтэй. Эхнэр нөхөр хоёулаа гэр бүлийн асуудалд шийдвэр гаргана. Гэрлэгчид нь гэр бүлийн энгийн харилцаа, үүнтэй холоотой асуудалд бие биеэ төлөөлнө.

Дундын эд хөрөнгө гэж юу бэ?

- Гэрлэснээс хойш хамтран амьдарсан хугацаанд бий болсон тухайн гэр бүлийн гишүүний хуваарьт хөрөнгөөс бусад **хөрөнгө ордог (эхнэр нөхөр хоёрын хамтын өмч хөрөнгө – společné jmění manželů (SJM))**. Гэр бүлийн гишүүний хуваарьт хөрөнгө нь бэлэг болон өвлөх журмаар ирсэн эд хөрөнгө. Цаашид гэрлэснээс хойш хамтран амьдарсан хугацаанд бий болсон эд хөрөнгө дундын нэр дээр байхаас гадна холбогдох үүрэг бас хамаарна. Гэр бүлийн нэг нь зээл буюу санхүүгийн гэрээ хийсэн бол хариуцлага нь хоёуланд нь ирнэ. Тиймээс өр төлбөр дундын хамтын нэр дээр байдаг. Гэр бүлээ цуцлуулах гэр бүлийн гишүүн өр төлбөрийн талаар мэдээгүй байсан ч тохиолдолд өмч хөрөнгийг хувааж авдаг.
- Эхнэр нөхөр хоёр одоогийн болон ирээдүйн **дундын өмчийн хэмжээг** нотариатаар баталгаажуулсан тэмдэглэл хэлбэр бүхий гэрээгээр **хязгаарлах (хамтын өмч хөрөнгийнхөө хэмжээг багасгах – zúžit společné jmění manželů)** эрхтэй. Эхнэр нөхөр хоёрын аль нэг нь дундын өмчийн хэмжээг хязгаарлуулахыг хүссэн, нөгөө нэг нь зөвшөөрөхгүй тохиолдолд шүүхэд хандаж болно. Хүндэтгэн үзэх шалтгаан буюу архи, хар тамхи, мөрийтэй тоглоомын дон зэрэг аюултай зан авираас шалтгаалсан тохиолдолд шүүх дундын өмчийн хэмжээг хязгаарлуулахыг хүссэн өргөдлийг хангахаар барахгүй дундын өмчийн хэмжээг зөвхөн гэрийн эд хогшилоор хязгаарлагдах шийдвэр гаргана. Эхнэр нөхөр хоёрын аль нэг нь бизнес эрхэлдэг тохиолдолд шүүх аль ч талын хүсэлтээр дундын өмчийн хэмжээг хязгаарлах шийдвэр гаргана.
- Дундын өмчлөлийг гэрлэлтийг бүртгүүлэхээс өмнө **Гэрлэлтийн гэрээгээр (předmanželskou smlouvou)** зохицуулж болно, гэрлэлтийн гэрээг нотариатчийн тэмдэглэлээр батлуулан байгуулдаг.

▶ 20. ИЖИЛ ХҮЙСТНИЙ ГЭРЛЭЛТ

- Ижил хүйстний гэрлэлтийн бүртгэлийг хамтын амьдралаа бүртгүүлэхийг зөвшөөрч буйгаа **мэдэгдсний** үндэслэн хийдэг. Мэдэгдэлийг иргэний бүртгэл мэдээллийн газрын албан хаагчын өмнө хийнэ. Хэлмэрчийг байлцуулж болно мөн протоколд гарын үсгээ зурна. Гэрчийг байлцуулах шаардлагагүй.
- **Бүргүүлэгчид насанд хүрсэн, ядаж хэн нэг нь ЧУ-ын иргэн байх ёстой**, мөн өмнөх гэрлэлт болон ижил хүйстний гэрлэлтээ цуцлуулаагүй байж болохгүй.
- Таны болон хамтрагчийнхаа оршин суугаа хаягийн дагуу гэрлэлтийн бүртгэлийн товчоотой холбоо бариарай. **Анхаар: ЧУ-д зөвхөн 14 иргэний бүртгэл мэдээллийн газар энэ бүртгэлийг хийдэг.**
- Бүртгүүлэгчидийн хэн ч ЧУ-д байнгын оршин суух хаяггүй бол, Брно-гийн төвийн бүсийн хотын захиргаанд иргэний бүртгэл мэдээллийн газар байдаг.

Гэрлэлтээ бүртгүүлэхэд шаардлагатай бичиг баримтууд:

- Төрсний гэрчилгээ, паспорт
- Гадаад улсад байгаа бол Гадаадын иргэнтэй гэрлэхэд эрх зүйн чадамжтай эсэхийг тодорхойлсон гэрчилгээ (6 сарын хүчинтэй)
- Гадаад улсад байгаа бол гэр бүлийн байдал, оршин суугаа хаягийн тодорхойлолт
- Өмнө нь гэр бүлтэй эсвэл ижил хүйстний гэрлэлтээр амьдарч байсан бол, гэрлэгч нас барсан гэж зарласан шүүхийн шийдвэр, гэрлэлтийг цуцласан гэрчилгээ, хамтын амьдралын бүртгэлийг цуцласан шүүхийн шийдвэрийг хавсаргаарай.
- Танд байнгын оршин суух зөвшөөрөл байхгүй бол ЧУ- дах хүчинтэй оршин суух зөвшөөрөлтэй гэсэн тодорхойлолтыг Гадаадын иргэдийн асуудал хариуцсан цагдаагийн газраас гаргуулан авч хавсаргаарай, тодорхойлолт ажлын 7 өдөрт хүчинтэй. Энэ тодорхойлолт ЕХ-ны гишүүн орны иргэнд хэрэггүй.
- Хэрвээ та олон улсын хамгаалалтанд эсвэл орогнол (azyl) авсан бол зарим бичиг баримтыг олж авах байдал нь бэрхшээл дагуулж болох талтай гэдгээр иргэний бүртгэл мэдээллийн газар харгалзаж үүнээс чөлөөлж болох юм.

<p>Иргэний бүртгэл мэдээллийн газрын жагсаалтыг эндээс харна уу: www.statnisprava.cz</p> <p>Шүүх яамны сайт-ын олон улсын харилцааны хэсгээс улс хоорондын чухал гэрээ хэлэлцээрүүд, олон улсын эрх зүйн тусламж зэргийг харж болно www.justice.cz.</p> <p>Хаагск-ийн гэрээнд гарын үсэг зурсан орнуудын жагсаалт эндээс харна уу: http://www.hcch.net/index_en.php?act=conventions.status&cid=41.</p> <p>Оршин суух зөвшөөрлийн дэлгэрэнгүй мэдээлэл ДХЯ-ны цагаачлалын албаны хаягийг эндээс харна уу: http://www.mvcr.cz/clanek/služby-pro-verejnost-informace-pro-cizince-kontakty.aspx.</p> <p>Энэхүү зөвлөмж болон бусад гадаад иргэдэд зориулсан бусад мэдээллийг эндээс харна уу: www.cicpraha.org/infoservis. Дэлгэрэнгүй мэдээлэл бусад зүйлээр гадаад иргэдийг интегралчилах төвд хандаарай www.cicpraha.org.</p> <p>CENTRUM PRO INTEGRACI CIZINCŮ o. s., Kubelkova 55, 130 00 Praha 3, Tel./fax: (+420) 222 713 332, Email: info@cicpraha.org</p> <p>Дунд Чех нутгийн ЦИЦ байгууллагийн салбар, Zahradní 46, Kolín, Tel.: 774 866 838, www.cicpraha.org</p> <p><i>Мэдээллийн агуулага хэвлэгдсэн хугацаандаа хүчинтэй, шаардлагатай өөрчлөлтийг эсэргүүцэх боломжгүй.</i></p>
--



ГАДААД ИРГЭНТЭЙ/ГАДААД ИРГЭД ХООРОНДОО ГЭР БҮЛ БОЛОХ

ЧУ-Д ХЭРХЭН ГЭРЛЭЛТЭЭ БАТЛУУЛАХ ВЭ?

- Та **иргэний гэрлэлтийн (албан ёсны гэрлэлт – občanský sňatek)** бүртгэлээ гэрлэлтийн бүртгэлийн товчоо эсвэл **шашны ёслолоор (církevní sňatek)** сүм болон шашины байгууллагын өмнө сонгож хийж болно.
- Гэрлэлтийг насанд хүрсэн эрэгтэй эмэгтэй хүмүүсийн сайн дурын үндсэн дээр батладаг.
- **Сүй тавигсад (snoubenci)** нь гэр бүл болохыг хүсэж буй хүмүүс юм.
- Мэдэгдэлийг нийтийн өмнө баяр ёслолын хэлбэрээр насанд хүрсэн хоёр гэрчийг байлцуулан үйлдэж болно.
- Албан ёсны байгууллага **нь иргэний бүртгэл мэдээлэлийн газар (matiční úřad)**.

Хуримыг ихэнхдээ хэдэн сарын өмнөөс төлөвлөх хэрэгтэй учир нь бичиг баримтыг бүрдүүлэхэд тодорхой хугацаа шаардлагатай. Хаана хуримаа хиймээр байна тэр газрынхаа гэр бүл бүртгэлийн газар биеэр очоорой. Гэр бүл бүртгэлийн товчоо хотын захиргаа эсвэл дүүргийн захиргаан дээр байдаг.

▶ 1. ЯМАР БИЧИГ БАРИМТЫГ ГЭР БҮЛ БҮРТГЭЛИЙН ТОВЧООНД АВЧРАХ ВЭ?

Байнгын болон удаан хугацааны оршин суух эрхтэй, ЕХ-ны гишүүн бус орны гадаад иргэд дараах бичиг баримтыг бүрдүүлнэ:

- төрсний гэрчилгээ
- иргэний харъяалалын баримт- паспорт
- гадаадын иргэнтэй гэрлэхэд эрх зүйн чадамжтай эсэхийг тодорхойлсон баримт
- зарим тохиолдолд гэр бүлийн байдал, оршин суугаа газрын тодорхойлолт

Энэ танилцуулага гуравдагч орны иргэний интеграцад зориулан Европын сангаас дэмжлэг авсан төсөл юм.



MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY

- ЧУ-д албан ёсны оршин суух зөвшөөрөлтэйг батласан баримт
- хэрвээ та өмнө нь гэрлэж байсан тэр гэрлэлт дуусгавар болсоныг нотлох баримт

2. ГАДААДЫН ИРГЭНТЭЙ ГЭР БҮЛ БОЛОХОД ЭРХ ЗҮЙН ЧАДАМЖТАЙ ЭСЭХИЙГ ТОДОРХОЙЛСОН ГЭРЧИЛГЭЭ

- Гадаадын иргэнтэй гэр бүл болоход эрх зүйн чадамжтай эсэхийг тодорхойлсон гэрчилгээ нь Европын холбооны гишүүн орны иргэдэд байх ёстой.
- Гэрлэхэд эрх зүйн чадамжтай эсэхийг тодорхойлсон гэрчилгээ буюу баримт (vysvědčení o právní způsobilosti k uzavření manželství) нь дараах мэдээллийг агуулсан байна:
 - гэрлэхийг хүсэгч нарын нэр овог, төрсөн он сар өдөр, төрсөн газрын нэр
 - байнгын оршин суудаг газрын мэдээлэл (байнгын оршин суудаг газрын хаяг, ЧУ дах хаяг эсвэл төрсөн орон нутаг дах хаяг байж болно)
 - иргэний харъяалал
 - гэрлэхэд харшлах шалтгаан байхгүйг нотлосон тодорхойлолт
 - танд өөр албан ёсны гэрлэлт байхгүй гэсэн мэдээлэл (та заавал гэрлээгүй ганц бие байх шаардлагатай эсвэл салсан, бэлэвсэн байж болно)
 - олгосон огноо, байгууллагын тамга тэмдэг, албан хаагчын овог нэр, гарын үсэг
- Энэ баримт гэрчилгээг танд таны харъяалалын улс олгоно. Өөрийн харъяа улс руу явах эсвэл өөрийн элчин сайдын яамнаас баримтыг хэрхэн авч болох талаар асуугаарай.
- Гэрчилгээнд зарим мэдээлэл бичигдээгүй бол тухайн мэдээллийг агуулсан тодорхойлолт тусдаа хавсрагдсан байх ёстой (жнь: оршин суух зөвшөөрлийн тухай тодорхойлолт, иргэний харъялалын бичиг баримт г.м.).
- Хэрвээ танд тодорхойлолтыг гаргуулахад **ноцтой бэрхшээл тулгарсан** мөн ямар нэгэн хүндэтгэх шалтгааны улмаас боломжгүй бол өөрийн иргэний харъялалын элчин сайдын яаман дээр **консулын өмнө энэ тухай батламж бичиг** үйлдэж болно. Тухайн нутаг дэвсгэрт консул байхгүй бол ЧУ-ын гадаад хэргийн ямаар дамжуулан консулын баталгаат гарын үсэг бүхий бичгийг авч болно.
- Баримт гэрчилгээ нь гаргаснаас хойш зургаан сарын турш хүчинтэй.

3. ГЭР БҮЛИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ ТОДОРХОЙЛОЛТ

- Гадаадын иргэнтэй гэр бүл болоход эрх зүйн чадамжтай эсэхийг тодорхойлсон гэрчилгээнд гэр бүлийн харилцаа, байнгын оршин суух хаягийн талаар бичигдээгүй бол, **оршин суух ба гэр бүлийн байдлын талаарх тодорхойлолтыг** (potvrzení o rodinném stavu a robytu) олж авахад анхаарах ёстой.
- Энэ баримт гэрчилгээг танд таны харъяалалын улс олгоно.
- Өөрийн харъяа улс руугаа явах эсвэл өөрийн элчин сайдын яамнаас баримтыг хэрхэн авч болох талаар асуугаарай.
- Баримт гэрчилгээ нь зургаан сарын турш хүчинтэй.

4. ЧУ ДАХ ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮЧИНТЭЙ ЭСЭХ ТОДОРХОЙЛОЛТ

- Гадаадын иргэдийн асуудал хариуцсан цагдаагийн газраас харъяалалын дагуу өөрийн биеэр очиж хүсээрэй. ***Анхаар! Та энэ тодорхойлолт авахын төлөө ЧУ-ын дотоод хэргийн яамны цагаачлал шлжин сууршилтын албаны салбарт очихгүй харин гадаадын харъяатын цагдаагийн газарт очоорой.*** Энэ тодорхойлолтыг гэрлэлтээ бүртгүүлэх хугацаанаас долоон хоногийн өмнө авахаар тооцоорой. Энэ тодорхойлолт **ажлын долоон өдөрт хүчинтэй** байдаг. Энэ тодорхойлолтыг Европын Холбооны Эдийн Засгийн Хамтын Нийгэмлэг эсвэл ЕХ-ны гишүүн орны иргэн, түүний гэр бүлийн гишүүд бүрдүүлэх шаардлагагүй.
- Танд гадаад паспорт, марк (шуудангаас худалж авдаг) хэрэгтэй.
- Энэ тодорхойлолтыг бүртгэлийн товчооны ажилтанд хамгийн оройтохдоо гэрлэх өдрөө авчирж өгөөрэй.

5. ДАРААГИЙН БАРИМТ БИЧИГ, ХЭРВЭЭ ТА ӨМНӨ НЬ ГЭРЛЭЖ БАЙСАН БОЛ

- Та бэлэвсэн бол- таны эхнэр/нөхөр нас барсан:** энэ тухай зарласан баримтыг гэрчилгээнд хавсаргана. Хэрвээ гадаадын иргэнтэй гэр бүл болоход эрх зүйн чадамжтай эсэхийг тодорхойлсон гэрчилгээнд энэ тухай бичигдсэн бол заавал түүнийг нас барсаныг зарласан тухай баримтыг хавсаргах шаардлагагүй.
- Хэрвээ та гэр бүлээ цуцлуулсан бол-** гэрлэлтийг дуусгавар болсон тухай шийдвэрийг бичиг баримтанд хавсаргана. Шийдвэр нь хуулийн эрх бүхий байгууллагаас гарсан байх ёстой. Гадаад улсын шүүхийн шийдвэр бол түүний үнэн зөвийг баталсан байх ёстойгоос гадна (олон улсын гэрээ хэлэлцээрт

өөрөөр заагүй бол дээд байгууллагаар баталгажуулсан эсвэл Апоcтиль гэрчилгээтэй байна) шийдвэрийг чех хэл дээр орчуулж, орчуулга нь нотариатаар батуулсан байх ёстой.

- Хэрвээ өөр улсад гэр бүлээ цуцлуулсан ба эхнэр нөхрийн аль нэг нь ЧУ-ын иргэн бол ЧУ-ын Дээд шүүхэд тухайн шийдвэрийг баталгажуулах өргөдөл гаргана. Зарим онцгой тохиолдолууд байдаг: шийдвэрийг гаргасан улстай ЧУ олон улсын гэрээ хэлэлцээр байгуулсан эсвэл тухайн улстай гэр бүл цуцласан шүүх, захиргааны шийдвэрийг хүчинтэй тооцно гэсэн гэрээнд (Хаагскийн гэрээ) гарын үсэг зурсан бол Дээд шүүхээс шийдвэрийг хүчинтэйд тооцох өргөдөл гаргах хэрэггүй.

6. БАРИМТ БИЧГЭЭС ЧӨЛӨӨЛӨХ

- Онцгой нөхцөлд ямар нэгэн бичиг баримтыг өөрийн харъяалалын улсаасаа гаргуулах боломжгүй бол иргэний бүртгэл мэдээллийн газраас энэ баримтаас чөлөөлөх тухай хүсэлтийг гаргаж болно.
- Энэ зарим бичиг баримтыг олж авах байдал нь бэрхшээл дагуулж болох талтай байгаа тухай тодорхойлолт эсвэл батламж бичгийг хавсаргаарай. Ихэнхдээ олон улсын хамгаалалт хүсэгчидэд хамаардаг.
- Иргэний бүртгэлийн газар таны өргөдлийг 30 хүртэлх хоногт шийдвэрлэдэг.

7. БҮХ БИЧИГ БАРИМТАД ХАМААРАХ

- ЧУ-аас өөр улсад гаргуулсан баримтууд чех хэл дээр албан ёсны орчуулагч орчуулсан, нотариатаар батлуулсан байх ёстой.
- Жинхэнэ (эсвэл нотариатаар батлуулсан) хувь бүрд орчуулга болон орчуулагчийн нэмэлт тайлбар хавсарсан байх шаардлагатай
- Анхаар! бичиг баримт бүр тусдаа орчуулсан баталгажуулсан байх ёстой. Энэ тухай орчуулагчид анхааруулаарай.***
- Орчуулагч таны нэрийг зөв бичсэн, жинхэнэ эх бичиг баримтан дээрхтэй таарч байгаа эсэхийг шалгаарай, ЧУ-д орон сууцны зөвшөөрлийн картанд (obytový štítek) чех хэлний галигаар бичигдсэн шиг байж болохгүй.**
- Словак улсын албан байгууллага, шүүхээс гаргасан бичиг баримтуудыг орчуулах шаардлагагүй.

8. БИЧИГ БАРИМТЫГ БАТАЛГАЖУУЛАХ

- Зарим улсаас гаргаж буй баталгаат тодорхойлолыг үнэн зөв эсэхийг батлах үүднээс - **Апоcтиль-ийн конвенцд (ověřovací doložka Apostille)** нэгдэн орсон эсвэл **дээд байгууллагаар баталгажуулсан (superlegalizace)** зэрэг нэмэлт тайлбарыг хавсаргадаг. Иргэний бүртгэлийн газрын ажилтан танд баталгаанд өөр юу хэрэгтэйг тайлбарлана.
- Баталгаат баримтыг гаргаж байгаа улс бүртэй ЧУ олон улсын гэрээ байгуулсан байх шаардлагагүй. Албан ёсны баримт бичгийг баталгажуулах шаардлагыг халах тухай олон улсын конвенцид нэгдсэн улс нотариатаар батлуулах шаардлагагүй – Апоcтилийн конвенцд нэгдэн орсон эсвэл дээд байгууллагаар баталгажуулсан зэрэг нэмэлт гэрчилгээг хавсаргадаг. Иргэний бүртгэлийн газрын ажилтан танд баталгаанд өөр юу хэрэгтэйг тайлбарлана.
- Апоcтиль гэрчилгээг хавсаргахыг хилийн чанадад албан ёсны бичиг баталгажуулах шаардлагыг халах агуулгатай Хаагск-ийн гэрээнд гарын үсэг зурсан орнууд шаарддаг. Энэ гэрчилгээг тухайн улс дах тодорхой байгууллага хийнэ - ихэвчлэн Гадаад хэргийн яам зарим үед Шүүх яам.
- Дээд байгууллагаар батлуулахыг хилийн чанадад гаргасан албан бичиг дээр шаарддаг. Эхлээд олгосон улсын гадаад явдлын яаманд баталгажуулж (гадаад явдлын яам бичгийн агуулгаас шалтгаалж өөр яамны баталгааг шаардаж болно), дараа нь тус улсын төлөөлөгч ЧУ-ын элчин сайдын яам баталгажуулна. Ингээд албан ёсны бичиг дээр гарын үсэг зурж тамга дарснаар Дээд байгууллагаар баталгажуулалт хүчинтэй болно.

9. ГЭРЛЭЛТИЙН ТОВЧООНД ГЭРЛЭЛТ БҮРТГЭХ

- Иргэний бүртгэлийн товчооны ажилтан таны бичиг баримт бүрэн эсэхийг шалгана.
- Гэрлэхийг хүсэгчид хоёулаа баталгаат биеийн байцаалт, **гэрлэлтэнд шаардлагатай асуултуудыг бичсэн маягтыг (dotazniku k uzavření manželství)** өөрийн биеэр гарган авна, үүнийг бөглөхөд та бүхэнд албан хаагч туслаж болно.
- Хуримтай холбоотой дараагийн арга хэмжээний хугацааг тохиролцоорой.

10. ОВОГИЙН СОНГОЛТ

Гэрлэлтийн дараа хэрэглэх овогоо асуултаны дагуу бичээрэй. Мөн та үүгээрээ таны хүүхдүүд ямар овогоор овоглохыг сонгож байгаа болно. Хэрвээ таны овог өөрчлөгдөж байгаа бол хуримын дараа гадаад паспортаа

солиулах хэрэгтэй. Танд дараах боломж байна:

- Гэрлэлтээ бүртгүүлэгчид хэн нэгнийхээ овогийг нэгдсэн овогоо болгох.
- Өөр өөрийнхөө овогийг хэвээр үлдээх.
- Нэгдсэн овог хэрэглэхээр бол аль нэг нь өөрийн жинхэнэ овогийг давхар авч болно (хоёроос дээш овогийг нийлүүлэн хэрэглэж болохгүй).
- ЧУ-д та олон овог хэрэглэж болно, таны хүүхдүүд ч мөн адил.
- Эмэгтэйчүүд чех хэлний дүрмээр овогийн төгсгөлд -ová- нөхцөлийг хэргэлдэг. Жнь: Novak-Novaková. Гадаад эмэгтэй өөрийн овогийг -ová- төгсгөлгүйгээр хүсэж болно. Үүнийг өөр харъяалалтай эмэгтэй хүүхдийг төрөхөд түүний төрсөний гэрчилгээг бичихэд хэрэглэдэг.

11. ХУРИМ ОНЦГОЙ ГАЗАРТ

– Хэрвээ та хуримаа гэрлэлтийн баталгаа олгодог гэрлэлтийн бүртгэлийн товчооноос өөр газар хийхийг хүсвэл (жнь: байгальд, эмнэлэгт...) бүртэлийн товчооноос урьдчилан хүсэж өргөдөл гаргах хэрэгтэй.
– Өргөдлийг өөрсдөө бичээд сонгосон газрынхаа гэрлэлтийн бүртгэлийн товчоонд гаргаарай. Өргөдлийг гэрлэхийг хүсэгчдээс нэг нь гаргаж болно. Нөгөө хүнээсээ итгэмжлэл авсан байхад хангалттай. Гарын үсэг нь заавал нотариатаар баталгажуулсан байх албагүй. Итгэмжлэлийн маягыг **www.jaknapsat.cz** эндээс авч болно.
– Гэрлэлтийн бүртгэлийн товчоо таны өргөдлийг зөвшөөрхийн тулд таны сонгосон газар зохистой байх хэрэгтэй.

12. ЧЕХ ХЭЛЭЭР ОЙЛГОДОГҮЙ, ЯРИДАГҮЙ ТОХИОЛДОЛД

- Гэрлэх ёслолд зориулж өөрсдөө тохиролцон эсвэл товчооны албан хаагчын зөвлөснөөр албан ёсны орчуулагч байлцуулах.
- Орчуулагч өөрийн бичиг баримттайгаа гэрлэх ёслолд ирэх.

13. ГЭРЛЭХ ЁСЛОЛ ХЭРХЭН ЯВАГДДАГ ВЭ?

- Гэрчүүд ирнэ, шаардлагатай тохиолдолд орчуулагч ирнэ.
- Гэрлэлтийн бүртгэлийн товчооны ажилтан бүх оролцогчидын биеийн байцаалт, шаардлагатай бичиг баримтыг шалгана.
- ЧУ-д насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүс гэр бүл болж үр хүүхдээ өсгөх гол зорилготойгоор гэрлэлтээ бүртгүүлэх эрхтэй. Иймээс гэрлэлтийн бүртгэлийн товчооны албан хаагч гэрлэх ёслолын эхэнд гэрлэхийг хүсэгчидэд „гэрлэхийг хүсэгчид гэр бүл болсоноор зөвхөн ойр дотны хүмүүс биш болж бие биеэ халамжлах, ирээдүйн орон гэр, амины болон эд хөрөнгийн үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүд“ болж буйг хэлнэ.
- Ёслолын төгсгөлд гэрлэхийг хүсэгчидээс сайн дурын, чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн дээр гэр бүл болж байна уу? гэж асууна. Орчуулагч байгаа нөхцөлд ч та чех хэлээр „**ано**“ (тийм гэсэн утгатай) гэж хариулна. Үүгээр та гэр бүл болсноор үүдэн гарч буй эрх, үүрэгийг хүлээн авч байгаа болно.
- Гэрлэгчид болон гэрч нар гэрлэлт бүртгэх дэвтэрт гарын үсэг зурцгаана.

ШАШНЫ ЁСЛОЛООР ГЭРЛЭХЭЭР ШИЙДСЭН ҮҮ?

14. ЮУН ТҮРҮҮНД ХИЙХ ЗҮЙЛС:

- Гэрлэлтийг зөвхөн улсаас олгосон эрх бүхий хүний өмнө шашин болон шашины нийгэмлэг бүртгэж болно.
- Та иргэний (захиргааны) журмаар гэрлэлтээ бүртгүүлэхэд шаардлагатай бичиг баримтуудтай ижил материалуудыг бүрдүүлдэг.
- Тухайн шашины байгууллага хаана байдаг тэр нутаг дэвсгэрийн гэрлэлтийн бүртгэлийн товчоонд очоорой.
- Өөрийн биеэр „Шашины ёслолоор гэрлэхэд Гэр бүлийн хуулиар заасан нөхцөл болзлыг хангасан тухай гэрчилгээ“-г (Osvědčení o splnění požadavků zákona o rodině pro uzavření církevního snatku) хүсээрэй. Энэ гэрчилгээг хуримын өдөр шашиныг төлөөлж буй хүнд өгөх ба гэрчилгээг авсанаас хойш 3 сарын дотор хүчинтэй.
- Гэрлэлтээ батлуулсанаас хойш 3 ажлын өдөрт гэрлэлтийн тухай протокол бүртгэлийн товчоонд ирнэ.